

XXI ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛ-ХЯТАДЫН ХАРИЛЦАА: ШИНЭ БОЛОМЖ, ШИНЭ СОРИЛТ

Д.Шүрхүү*

Хоёр зууны заагаар Монгол-Хятадын харилцаа шинэ үе шатандаа дэвшин орж буйтай маргах хүн гарахгүй болов уу. Харин шинэ үе шатыг тодорхойлж байгаа хүчин зүйл, ялангуяа ойрын болон дунд хугацааны хэтийн төлвийн талаар мэргэжил нэгт нөхдүүд, улс төрчид, шинжээчид янз бүрийн санал дүгнэлт, таамаглал дэвшүүлж болох юм. Доктор Ц.Батбаяр Монгол-Хятадын харилцааны сүүлийн 20 орчим жилийг 3 үе шатанд хуваан авч үзжээ. Тухайлбал 1987-1991 он буюу эхний шатанд хоёр талын харилцаа бүрэн хэвийн болсон, 1991-1994 он буюу хоёрдахь шатанд харилцааны хууль эрх зүйн шинэ үндэс тавигдсан, 1994-2005 он буюу гуравдахь шатанд шинэ зууны хоёр орны харилцааны чиг хандлагыг тодорхойлсон өндөр дээд хэмжээний харилцан айлчлалуудаар дүүрэн байсан тухай онцлон тэмдэглэсэн байна.¹ XXI зууны эхээр Монгол-Хятадын харилцаа шинэ үе шатанд орсныг хоёр орны төрийн тэргүүнүүдийн 2003 он (Ху Зиньтао) болон 2004 онд (Н. Багабанди) хийсэн дээд хэмжээний айлчлалууд нотлон харуулсан билээ. Хоёр тал харилцан итгэсэн сайн хөршийн түншлэлийн харилцаа тогтоон хөгжүүлэхээр тохиролцсон нь орчин үеийн Монгол-Хятадын харилцааны шинэ үе шатны гол онцлог юм.

Монгол-Хятадын харилцааны шинэ үе шатны үйл явцыг улс төр, эдийн засгийн болон дотоод, гадаадаас эх сурвалж бүхий олон хүчин зүйлүүд тодорхойлон тодотгож байна. Үүнд:

1. Хоёр орны улс төр, нийгэм, эдийн засаг хөгжлийн шинэ төлөв байдалд шилжин орж байна. Сүүлийн 20 гаруй жил БНХАУ-ын эдийн засаг өндөр хурдацтай хөгжиж байна. Зөвхөн 2004 онд Хятадын эдийн засаг 9.5% өсч, ДНБ-ний хэмжээ 1.650 триллион ам.долларт хүрчээ. Гадаад худалдааны эргэлт 35.7% нэмэгдэж, 1100.0 тэрбум ам.долларт хүрсэн нь дэлхийд 3-рт орох үзүүлэлт юм. Гадаадын шууд хөрөнгө оруулалт 60.6 тэрбум ам.долларт хүрч дэлхийд тэргүүлсэн бол гадаад валютын нөөц нь бараг 1/3-ээр өсч 610 тэрбум ам.доллар болсноор зөвхөн Японы дараа орох болжээ.² 2001 онд Хятад улс Дэлхийн худалдааны байгууллагад элссэнээр Хятадын эдийн засаг дэлхийн интеграцид эргэлт буцалтгүй татагдан орж улмаар түүний хөгжлийн гол зүтгүүрийн нэг болж хувирч байна. Улс төрийн хүрээнд Ху Зиньтао тэргүүтэй Хятадын дөрөвдэх үеийн удирдагчид засгийн бүх эрх мэдлийг шилжүүлэн авах үйл явц дуусч байна.

* Д.Шүрхүү - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн хурдац эрс түргэсч, 2004 онд анх удаа 10.6 хувьд хүрсний зэрэгцээ их барилга, дэд бүтэц, уул уурхай, аялал жуулчлал зэрэг олон салбарын үйлдвэрлэл сэргэн, нийгэм эдийн засгийн хөгжлийг түргэтгэх дунд, урт хугацааны хөтөлбөрүүд (Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Мянганы зам, 40000 айлын орон сууц, Цахим Монгол, Ногоон хэрэм), томоохон төслүүд (Оюу толгойн зэс алтын орд, Таван толгойн нүүрс, Төмөртэйн цайр, Алтанбулаг, Замын-Үүдийн чөлөөт бүсүүд гэх мэт) хэрэгжиж эхлэх шатандаа орж байна. Монгол Улс ардчилал, зах зээлийн тогтолцоонд эргэлт буцалтгүй орсны зэрэгцээ өнгөрсөн жил болсон парламентын болон орон нутгийн сонгуулиуд, саяхан болсон ерөнхийлөгчийн сонгууль нь Монгол Улсад ардчилсан тогтолцоо хэр зэрэг бэхжсэнийг харуулах том шалгуур болсон юм.

2. Дэлхий, бүс нутгийн бодлого, аюулгүй байдлын салбарт гарсан өөрчлөлт. Даяаршил, олон улсын терроризм, уламжлалт бус аюул заналын өсөлт /экологийн хямрал, байгалийн гамшиг, халдварт өвчин, үндэстэн дамнасан гэмт хэрэг гэх мэт/ дэлхий дахины шинжтэй өөрчлөлтүүдийг дагууллаа. Ялангуяа 9.11-ны террорист халдлагын дараа олон улс орон аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлалаа эргэн харж, дэлхийн болон бүс нутгийн интеграцид идэвхитэй оролцох, хамтын аюулгүй байдлын тогтолцоог бий болгох, глобал асуудлуудыг хамтын хүчээр шийдвэрлэх хүсэл сонирхол нэмэгдэж байна.

3. Гадаад бодлогын өөрчлөлт. БНХАУ-ын гадаад бодлого, аюулгүй байдлын үзэл баримтлал 1990-ээд оны дунд үеэс ихээхэн хувьсан өөрчлөгдсөөр байна. Энэхүү хувьсал өөрчлөлтийн гол чиг хандлага нь улам бүр өргөжин тэлж буй эдийн засгийн хүч чадалдаа тулгуурлан үндэсний эрх ашгаа дэлхийн хэмжээнд хамгаалж чадахуйц хүч нөлөө, байр суурийг баттай эзлэх, улмаар олон улсын тавцанд өндөр нэр хүнд, үүрэг хариуцлага бүхий, дэлхийн бодлогыг тодорхойлогч хэт их гүрний дүр төрх бий болгоход чиглэж байна. Хятадын аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалын гол зарчмууд бол

- уламжлалт цэрэг - улс төрийн салбараас гадна амьдралын бүхий л хүрээг хамарсан олон талт байдал (comprehensive security)
- хөгжилд тулгуурлах, хөгжлийг тэтгэх замаар аюулгүй байдлын таатай орчин бүрдүүлэх (development security)
- хамтын хүчин чармайлт (cooperative security)
- бүх нийтийг хамарсан (common security) эдгээр болно.

Хятадын гадаад бодлогын үзэл баримтлал, зарчим өөрчлөгдсөнтэй уялдан дипломат бодлогын чиглэл, түүний зэрэглэл ч хувьсан өөрчлөгдөж байна. Хятадын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлд хөрш орнуудтайгаа найрсаг, түншлэлийн харилцаа тогтоон хөгжүүлэх,

их гүрнүүдтэй харилцан ашигтай, харилцан ойлголцсон ухаалаг харилцаа хөгжүүлэх, бүс нутгийн болон олон улсын олон талт хамтын ажиллагааны үйл явцад идэвхитэй оролцох явдал зүй ёсоор орж байна.

Монгол Улсын гадаад бодлогод сүүлийн жилүүдэд багагүй хувьсал өөрчлөлт гарч байна. Юуны өмнө бага буурай, эмзэг эдийн засагтай, эх газрын алслагдмал орны хувьд Монгол Улс эдийн засгийн дипломат бодлогыг олон талаар идэвхитэй явуулах зайлшгүй шаардлагатай. Сүүлийн жилүүдэд багагүй хүч чармайлт гаргасны үр дүнд нааштай эхлэл болох гадаадын хөрөнгө оруулалт нэлээд нэмэгдэж, олон талт хамтын ажиллагаа, ялангуяа Ази, Номхон далай түүний салбар бүсийн интеграци руу хандсан бодлогоо идэвхижүүлж байна.

4. Хоёр талын харилцаа бүх чиглэлээр өргөжин тэлж, улс төр, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа урьд өмнө байгаагүй өндөр түвшинд хүрээд байна.

Хятад бол Монгол Улсын худалдааны хамгийн том түнш мөн. 2004 онд Монгол, Хятадын худалдааны нийт эргэлтийн хэмжээ 671 сая ам.доллар болж Монголын гадаад худалдааны 30 орчим хувийг эзэлж байна. Түүний дотор Монголоос Хятад руу гаргасан экспорт 414 сая ам.доллар, импорт 257 сая ам.долларт хүрч Монголын гадаад худалдааны экспортын 47.6 %, импортын 25.2 %-ийг эзэлж байна. Хятад улс бол Монголын хамгийн том экспортлогч орон, импортын хувьд ОХУ-ын дараа 2-р байр эзэлдэг.³

БНХАУ Монголын хамгийн том хөрөнгө оруулагч. Хөрөнгө оруулалтын хувьд гэвэл, 1990 оноос 2004 оны эцэс хүртэл 75 орны 3668 аж ахуйн нэгж Монголд 1.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулахаар бүртгэгджээ. Хятад улс манайд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ (42.7%) болон хөрөнгө оруулалттай компаний тоо (40%) аль алинаар нь тэргүүлж байна. Хятадын хөрөнгө оруулагчид Монголд 523 сая ам.долларын хөрөнгө оруулсаны дотор геологи-уул уурхайн судалгаа, эрэл-хайгуул, олборлолт (259 сая ам.долл), худалдаа, нийтийн хоол (122.7 сая ам.долл), барилга, барилгын материалын үйлдвэрлэл (32.4 сая ам.долл), хөнгөн үйлдвэрийн салбарт (23.8 сая ам.долл) түлхүү хөрөнгө оруулалт хийтгээд байна.⁴ 1998 оноос Монгол дахь Хятадын хөрөнгө оруулалт тэргүүлэх байр суурь эзэлж байна.

Хятад, Монголын хамтарсан хамгийн том хамтын ажиллагааны төсөл бол Төмөртэйн овооны цайрын уурхай бөгөөд Хятадын тал 200 сая юанийн зээллэгэ олгож, Хятадын өнгөт төмөрлөгийн бүтээн байгуулалтын хувьцаат компани уурхайн ажлыг хариуцан хийж байна. Тус уурхай жилд 70 000 тн цайрын баяжмал гаргах хүчин чадалтай, ашиглалтын хугацаа 27 жил, нэг жилийн ашиг 18-20 сая ам.доллар болно.

Хятад улс Монголын “Мянганы зам”-ын их бүтээн байгуулалтанд чухал үүрэг гүйцэтгэж байгаа ба түүнд Хятадын зам барилгын 4 компани, 2000 гаруй инженер техникийн ажилтан, ажилчид оролцож байна. Энэ зам Монгол орныг зүүнээс баруун, урдаас хойш нэвт дайрах ба ОХУ, БНХАУ-тай шууд холбогдох тул ирээдүйд Ази-Европыг холбосон гол магистрал зам болох юм.

Үүнээс гадна Хятад улс Монголын баруун бүс нутгийг цахилгаан эрчим хүчээр хангах талаар үр ашигтай хамтран ажиллаж байна. 2004 оны 6-р сард Хятадын групп Дөргөний усан цахилгаан станцыг /УЦС/ барьж эхэлсэн ба Хятадын тал 2 жилийн дотор уг УЦС-ыг барих бөгөөд ингэснээр ОХУ-аас эрчим хүч импортлодог, эрчим хүчний үнийг төлөөгүйн улмаас гэрэл цахилгаан байнга тасардаг явдал эцэс болох юм.

Хятад улсаас Монголд үзүүлэх зээл тусламж улам бүр нэмэгдэх хандлагатай байна. Хятад, Монгол хоёр орон дипломат харилцаа тогтоосон 1949 оноос 2002 оны эцэс хүртэл Хятадаас Монголд нийтдээ 1 тэрбум гаруй юаний хөнгөлөлттэй зээл, тусламж үзүүлсэн байна. Харин 1991 оноос 2002 оны эцэс хүртэлх хугацаанд үзүүлсэн зээл тусламжийн хэмжээ 591 сая юаньд хүрсний дотор 130 сая юаний хүүгүй зээл, 200 сая юаний хөнгөлөлттэй зээл, бусад нь буцалтгүй тусламж ажээ. 2002 оны 6-р сард Хятадын Гадаад эдийн засаг, худалдааны яамны сайд Ши Гуаншэн Монголд айлчилж, Хятадаас 1950-1960-иад онд олгосон зээлийн хугацааг сунгаж, 2007 оноос хойш төлөхөөр тохиролцов. 2003 оны 6-р сард БНХАУ-ын дарга Ху Зиньтао Монгол Улсад айлчлах үед Хятадын тал Монголд 50 сая юаний буцалтгүй тусламж болон уул уурхайн баялгийг нээж ашиглах дэд бүтцийг хөгжүүлэхэд зориулан 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл олгохоор болов. 2003 оны 11-р сард Монгол Улсын Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан Хятадад айлчлах үед Хятадын тал Монголд дахин 30 сая юаний буцалтгүй тусламж олгов. Ингэснээр зөвхөн 2003 онд Хятадаас Монголд олгосон буюу олгохоор амласан зээл тусламжийн хэмжээ 2.56 тэрбум юаньд хүрсэн нь өмнөх 50 жилийн үзүүлэлтийг давж байна. Хоёр улс дипломат харилцаа тогтоосноос хойш өнөөг хүртэлх хугацаанд Хятад улс Монголд нийтдээ 3.6 тэрбум юаний зээл, тусламжийг үзүүлээд байна.⁵

Хилийн худалдаа Хятад, Монголын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд чухал байр суурь эзэлж байна. 1985 оноос эхлэн Монгол Улс БНХАУ-ын Өвөр Монгол, Синьзян-Уйгур, Нинся-Хотон, Хэбэй, Ганьсу, Зилинь зэрэг өөртөө засах орон, мужуудтай хилийн худалдаа хийж байна. Өвөр Монгол ба Монгол Улсын хооронд хийж буй хил худалдаа, техник-эдийн засгийн хамтын ажиллагаа нь Хятад, Монголын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаанд томоохон байр суурь эзэлдэг. 1983-2003 онд ӨМӨЗО, Монгол Улсын хоорондын

худалдааны хэмжээ 1710 сая ам.долларт хүрч, мөн үеийн хоёр орны худалдааны нийт хэмжээний (3190 сая ам.доллар) 54 % эзэлсэн байна. 2003 онд Өвөр Монгол, Монгол улстай хийсэн худалдаа 220 сая ам.доллар байсан нь тухайн онд Монгол Хятадын худалдааны нийт хэмжээний 46% болж байна.⁶

Монгол, Хятадын харилцаа хэвийн болсоноос хойш хоёр орны соёл, боловсролын салбар дахь харилцаа хамтын ажиллагаа хөгжин бэхжиж, янз бүрийн түвшинд, олон хэлбэрийн соёлын солилцоо, хамтын ажиллагаа явуулсны үр дүнд хоёр орны ард түмний харилцан ойлголцол нэмэгдсэн билээ. 2004 оны 4-р сард Хятад улсын Соёлын яам, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам хамтран Монголд “Хятадын соёлын өдрүүд”-ийг зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээнд хятадын үндэсний хөгжим, фото зургийн үзэсгэлэн, кино өдрүүд, цирк, дуу бүжгийн тоглолт багтсан байлаа. Энэ үеэр Хятад улсын Соёлын сайд Сунь Зяжэн Монголд зочилж, “Хятадын засгийн газар ба Монголын засгийн газрын хооронд 2004-2006 онуудад соёлын солилцоо хийх төлөвлөгөө”-нд гарын үсэг зурсан юм. Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2005 онд Хятад улсад “Монголын соёлын өдрүүд”-ийг амжилттай зохион явуулав.

1998 онд “БНХАУ-ын Засгийн газар ба Монгол Улсын Засгийн газар эрдмийн зэрэг, боловсролын үнэмлэхийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр”, 2000 онд “Хятадын буцалтгүй тусламжаар Монголын оюутныг сургах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд тус тус гарын үсэг зурав. Ерөнхийлөгч Н.Багабанди 2004 онд Хятад улсад айлчлах үеэр жилд 40 сурагч, оюутныг сургахаар гэрээ байгуулсан бөгөөд одоогоор 220 монгол оюутан Хятадын Засгийн газрын тэтгэлгээр суралцаж байна. 2005 оны 5-р сард Хятадын Ерөнхий сайдын орлогч УИ-гийн айлчлалын үеэр 100 оюутан нэмж сургахаар боллоо.⁷ Оюутан, мэргэжил дээшлүүлэгч, эрдэмтэн солилцоо жилээс жилд өсч Монголоос Хятадад улсын болон хувийн зардлаар суралцаж буй мэргэжил дээшлүүлэгч, оюутан, аспирантын тоо бараг 3000-д хүрч, Хятадаас Монголд мэргэжил дээшлүүлэгч, оюутны тоо 100 гаруй болоод байна. Хоёр талын хүн солилцоо нэмэгдэхийн хэрээр Монголд хятад хэл сурах хандлага сонирхол өсч байна.

Шинэ бололцоо

- Монгол Улс 1997 онд, Хятад улс 2001 онд Дэлхийн худалдааны байгууллагад элссэн, аль аль нь худалдаа, хөрөнгө оруулалтын орчинг либералчлах нээлттэй бодлого явуулах болсон нь хоёр талын хүсэл сонирхол, эрх ашигт бүрэн нийцэж байна.

- Хятадын эдийн засгийн түргэн хөгжил, шинэтгэл нээлттэй бодлого, глобалчлалын түрэлттэй нягт уялдсанаар Хятадыг дэлхийн худалдаа, үйлдвэрийн төв болгон хувиргаж байна. Монгол Улс өөрийн хэрэгцээт

бараа, бүтээгдэхүүнийг үнэ чанарын хувьд харьцангуй сонголт сайтай, ойр Хятадын зах зээлээс авах, мөн өдрөөс өдөрт өргөжин тэлсээр буй том зах зээлд экспортоо нэмэгдүүлэх түүхэн боломжийг олж авч байна.

- Хоёр орны эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа харилцан нөхөх, харилцан бие биеэ түших голдрилд орж байна. Нэг талаас Монгол улс олон мянган жил хэвлийдээ нууж ирсэн байгалийн асар их баялаг нөөцийнхөө үүшийг нээж, нөгөө талаас Хятадын том эдийн засгийн үсрэнгүй хөгжил уул уурхай, ашигт малтмалын асар их эрэлт хэрэгцээ үүсгэж байна. Хэрэв Хятадын зах зээлийн ийм тэлэлт байгаагүй бол Монгол Улс дэлхийн геологи хайгуул, уул уурхайн салбарын анхаарал сонирхлыг татсан хамгийн халуун цэг болж чадахгүй байсан болов уу.

- Орос-Хятадын стратегийн түншлэл гүнзгийрч, худалдаа, эдийн засгийн харилцаа өргөжин тэлж байгаа нь энэ хоёр их гүрний дунд байрладаг Монгол Улсад газар зүйн байршлын давуу талаа ашиглах, хоёр том зах зээлийн бараа, бүтээгдэхүүний урсгалыг өөрийн нутгаар дайран өнгөрүүлэх замаар тээвэр, зуучлал, үйлчилгээнээс асар их орлого олж болох түүхэн нөхцөл бололцоо бүрдэж байна. Гагцхүү үүнийг хэрхэн богино хугацаанд бодит байдал болгох нь манай улсын засаг төрийн бодлогын алсын хараа, бизнесменүүдийн овсгоо, нийт монголчуудын хичээл зүтгэлээс ихээхэн хамаарна.

- Монгол-Хятадын хил залгаа нутгуудад гол төлөв угсаа гарал, амьдрал ахуй, хэл соёл нэгтэй өвөр монголчууд тархан сууж байгаа нь худалдаа, эдийн засгийн төдийгүй, соёлын солилцоог өргөжүүлэхэд бас нэг чухал эерэг хүчин зүйл, мэдээлэл зуучлалын чухал үүрэг гүйцэтгэж байна.

Шинэ сорилт, бэрхшээлүүд

Монгол, Хятадын харилцааны шинэ үе шат багагүй сорилт, шалгалтуудыг даван туулах болно. Үүнд:

- Юуны өмнө хоёр талын үндсэрхэх үзлийн тулгаралт хүчтэй болох хандлага байна. Монголын нийгмийн сэтгэл зүйд олон зууны турш хэвшин тогтсон Хятад төвийн үзлийг эсэргүүцэх, Хятадаас хараат байдалд орохоос айн болгоомжлох явдал хүчтэй хэвээр байна. Хэдийгээр монголчууд зах зээлийн тогтолцоонд шилжсэнээр ажил хэрэг, соёл боловсрол, эмчилгээ, аялал жуулчлалын шугамаар Хятад руу зорчих явдал ихэссэн, хятад худалдаачид, бизнесменүүдтэй янз бүрийн түвшинд хэлхээ холбоо тогтоох, түншийн харилцаатай болсны үр дүнд Хятад орон, хятад үндэстний талаарх үзэл ойлголт нэлээд өөрчлөгдсөн боловч хятадын эсрэг үзэл олон нийтийн дунд түгээмэл хэвээр байна. Нөгөө талаас хятадын нийгэмд улс орны хүч чадал өсөн нэмэгдэхийн хэрээр улам бүр хүчээ авч буй үндсэрхэх үзлийн далбаан дор Ар Монголчуудыг эх газартай нэгтгэх их гүрний дээрэнгүй үзэл янз бүрийн шугамаар, түүний дотор янз бүрийн вэбсайтаар дамжин илрэх явдал

- Хятадын цэргийн хүч чадал тасралтгүй бэхжин зузаарч, батлан хамгаалах зардал төсөв нь байнга өсөн нэмэгдэж байгаа нь Монголын олон нийтийн дунд анхаарал, болгоомжлолыг өөрийн эрхгүй төрүүлсээр байх болно.

- Хэдийгээр Монгол-Хятадын эдийн засаг харилцан нөхөх, бие биеэ тэтгэх асар их потенциалтай боловч Монголын жижиг эдийн засгийн зарим гол бараа бүтээгдэхүүний зах зээлд хятадууд хүчтэй өрсөлдөгчид болдог. Тухайлбал, ноолуур, жонш, хүнсний бүтээгдэхүүн, оёмол сүлжмэл, аялал жуулчлалын салбарыг дурьдаж болох юм.

- Аюулгүй байдлын уламжлалт бус хүчин зүйлийн аюул занал улам бүр өсөн нэмэгдэж байна. Тухайлбал, ДОХ, үндэстэн дамнасан гэмт хэрэг, байгалийн гамшиг, цөлжилт, халдварт өвчин гэх мэт. Хөрш орнуудын хувьд SARS, шувууны ханиад, шүлхий зэрэг халдварт өвчнүүд улс дамнасан тархвал хоёр талын харилцаа, эдийн засагт ямар их хохирол учруулж болохыг тун саяхны практик тодорхой харуулсан. ДОХ-ын халдвар сүүлийн жилүүдэд Ази, түүний дотор Хятад улс, мөн манай оронд ч тархалтын цар хүрээ нэмэгдэх хандлагатай байна.

- Их гүрнүүдийн өрсөлдөөн, ялангуяа АНУ-Хятад, АНУ-ОХУ, Япон-Хятадын стратегийн сөргөлдөөн Монгол, Хятадын харилцаанд шууд болон дам байдлаар нөлөөлж болзошгүй.

Дүгнэлт, санал

БНХАУ-ын дарга Ху Зиньтао шинэ албан тушаалд томилогдсоныхоо дараа хийсэн анхны айлчлалынхаа хүрээнд 2003 оны 6 дугаар сард Монгол Улсад айлчилсан нь тус улсын шинэ үеийн удирдагчид манай улстай харилцахад чухал ач холбогдол өгч байгаагийн илэрхийлэл болсон билээ.

Монгол, Хятадын сайн хөршийн харилцан итгэсэн найрсаг харилцааны өнөөгийн хүрсэн түвшинг бататгаж, агуулгыг улам баяжуулсан, харилцааг XXI зуунд хөгжүүлэх тулгуур баримт бичгүүдийг амьдрал практикт хэрэгжүүлэх томоохон зорилт урган гарч байна.

Хоёр талын харилцааны гол чиг хандлага нь худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг олон хэлбэрээр хөгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, байгалийн баялаг, дэд бүтцийг хөгжүүлэхэд голлон анхаарч, Монгол Улсын цаашдын ирээдүйн хөгжилд тус дэм болохуйц салбарт томоохон зээл тусламж, төсөл хэрэгжүүлэхээр тохиролцсон болно.

Дээр дурдсан таатай нөхцөл бололцоог бүрэн гүйцэд ашиглах, ойр болон дунд хугацаанд тулгарч буй сорилт бэрхшээлүүдийг амжилттай даван туулж хоёр талын харилцан ашигтай хамтын ажиллагааг урт удаан хугацаанд тогтвортой хөгжүүлэх үүднээс дараах судалгааны болон бодлогын чанартай зарим саналуудыг дэвшүүлж байна.

- Монгол-Хятадын харилцааг шинэ агуулга, шинэ зорилго, шинэ нөхцөл байдалд тохируулан олон шинэлэг байдлаас хандах, хөрш том жижиг орнуудын харилцан ашигтай түншлэлийн харилцааны шилдэг загварын судалгааг эрчимжүүлэх, XXI зууны дэлхийн супер их гүрэн болж буй өмнөд хөршийн талаарх үзэл ойлголт, хандлагыг эрс өөрчлөн шинэчлэх, хоёр талын харилцааг олон талаас нь, шинэлэг хандлагаар харах хэрэгтэй байна. Юуны өмнө Ази, Номхон далай руу чиглэсэн интеграцид орохын тулд Хятадтай оновчтой, харилцан ашигтай интеграцид орох зайлшгүй шаардлагыг бодитой ав үзэх, энэ үйл явц дунд гарч ирэх өргөн бололцоо боломж, эрсдэл, сорилтуудыг сайтар судлан урьдчилан харах ч тулгамдсан зорилтуудын нэг болоод байна.

- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ОХУ, БНХАУ-тай харилцах дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх үйл явцад судлаач эрдэмтдийг идэвхитэй татан оролцуулж, олон түмний санал бодлыг тусгах хэрэгтэй байна. Дунд хугацааны стратеги боловсруулахдаа судлаач эрдэмтдийн болон олон түмний санал хүсэлтийг өргөн хүрээтэй тусгах, зарим асуудлыг хоёр талын болон гадаадын туршлагатай эрдэмтдийн туршлага зөвлөмжийг авч болох юм.

- Энэ дашрамд хэлэхэд энэхүү хурлыг хамтран зохион байгуулж буй Васадагийн их сургууль, Хятадын Ази, Номхон далайн хүрээлэн, мөн Монголын холбогдох хүрээлэн, их сургуулиудыг оролцуулан цаашид Зүүн Азийн хамтын нийгэмлэг, интеграцийн хэтийн төлөв, түүнд Монгол хэрхэн оролцох талаар хамтарсан судалгаа хийх, эрдэмтдийн иймэрхүү уулзалтуудыг тогтмол явуулах саналыг дэвшүүлж байна.

- Умард Азийн чөлөөт худалдааны орон зай буюу Азийн НАФТА-г (North Asian Free Trade Agreement) юуны өмнө ОХУ, Монгол, Хятад 3 орны хүрээнд байгуулах боломжийг судлан, боломжтой бол яриа хэлэлцээг ойрын үед хийж эхлүүлэх саналыг судлаачийн хувьд дэвшүүлж байна. Дамжин өнгөрөх тээврийн талаар Монгол-Орос-Хятад гурван талын хэлэлцээр байгуулах үйл явц үүнийг хэрэгжүүлэх чухал үндэс суурь болох юм. Энэхүү чөлөөт худалдааны орон зай бий болгосноор манай улс дараахь давуу талуудыг олж авах юм. Үүнд:

- Хоёр хөрш орон Монголын худалдааны гол түнш, нийт гадаад худалдааны тэн хагасаас илүү хувийг эзэлдэг бөгөөд экспортын 50% нь Хятадад, импортын 1/3 нь ОХУ-д оногдож байна. Иймд хоёр хөршдөө илүү тааламжтай нөхцлөөр худалдаа хийх, өөрөөр хэлбэл, хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг хямд өртөг зардлаар олж авах, экспортын чадамж, цар хүрээг өргөтгөх нөхцөл бололцоо бүрдэнэ.

- Хөрөнгө оруулалтын орчин, манай зах зээлийн өрсөлдөх чадварыг эрс сайжруулна. Хоёр том хөршийн зах зээл рүү чиглэсэн томоохон хөрөнгө оруулалтын урсгал Монгол руу чиглэх боломжийг нэмэгдүүлнэ.

- Орос-Хятадын хооронд бараа бүтээгдэхүүний урсгалыг нэмэгдүүлж, манай улс тээвэр зуучлал, үйлчилгээнээс нэлээд ашиг орлого олох боломж бүрдэнэ. 2004 онд Орос-Хятадын худалдааны нийт эргэлт 2003 оныхоос 34.7 хувиар өсч 21.2 тэрбум ам.доллар болжээ. Хоёр орны эрх баригчид 2010 он гэхэд худалдааны хэмжээг 60-80 тэрбумд хүргэх зорилт дэвшүүлээд байгаа ажээ.⁸

Гэхдээ үндэсний үйлдвэрлэлийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх, манай гол гол экспортын бараа бүтээгдэхүүнд өрсөлдөөн бий болох, хоёр хөршийн зүгээс үзүүлэх дарамт шахалтаас дотоодын зах зээлээ хамгаалах, төлбөр тооцооны гэх мэт олон олон асуудлыг шийдвэрлэх шаардлага урган гарна.

Хоёр талын харилцаа хүнээр дамжин хэрэгжих тул соёл боловсролын талын харилцааг шинэ шатанд гаргах хэрэгтэй байна. Хоёр ард түмний харилцан ойлголцол, найрсаг харилцаа, ажил хэргийн хэлхээ холбоог хөгжүүлэн бэхжүүлэхэд, ахуй соёлын ялгаа, хэлний бэрхшээл ихээхэн саад бэрхшээл учруулж байна. Сүүлийн жилүүдэд Монголын олон мянган залуучууд Хятадын их дээд сургуулиудад орж мэдлэг боловсрол эзэмших, хятад хэл сурах сонирхол эрс нэмэгдэж байна. Гэтэл ихэнх тохиолдолд хувийн зардлаар өндөр хөлс төлж суралцах асуудалтай тулгарч байна. Монголчууд хөгжингүй орнуудын иргэдийн адил нөхцлөөр суралцах боломж маш бага тул хоёр талын албан ёсны хэлэлцээрээр хөнгөлөлтэй нөхцлөөр сурах бололцоо бүрдүүлбэл манай иргэдийн соёл боловсролд том хувь нэмэр болохын зэрэгцээ одоо нэгэнт мэдэгдээд буй хятад судлалын шинэ залуу боловсон хүчний асуудлыг шийдэхэд чухал түлхэц болно.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Dr. Tsedendamba Batbayar. Mongolian-Chinese Economic Cooperation as an important Factor in Northeast Asian Economic Regionalism. ERINA REPORT. Vol. 64 2005 JULY. Pp-38-42

2. 2005 оны 3-р сард Бүх Хятадын ардын төлөөлөгчдийн Их хурлын чуулган дээр Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Вэнь Зябаогийн тавьсан тайлан илтгэл. <http://www.xinhuanet.com/>

3. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл- 2004, УБ, 2005, хуудас-269-271

4. “Гадаадын шууд хөрөнгө оруулалтын тойм-2004” (дэд дэвтэр) товхимол, хуудас- 8-10

5. Наран. “Хятад Монголын сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцааны шинэ төлөв”, “Олон улс судлал” сэтгүүлийн 2004 оны №3, хуудас –31

6. Мөн тэнд

7. “Монголын мэдээ” сонин, 2005.09. 01-ний дугаар

8. Сергей Разов: Российско-китайское взаимодействие является стабилизирующим фактором в современных международных отношениях. 3 ноября 2005 года, www.interfax-china.ru